



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/19

Онги

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын Найз багийн нутаг “Бага баян” гэх газарт нутаглаж буй малчин Ж.Мягмарсүрэнгийн суурьт Бог малын мялзан өвчний шинж тэмдэг бүдгэрч эдгэрсэнтэй холбогдуулан 2023 оны 02 дугаар сарын 24-ны өдрөөс 03 дугаар сарын 10-ны өдрийг дуусах хугацаанд хязгаарлалтын дэглэмийг тогтоосугай.
2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсээс гарах мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хориглосугай.
3. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсэд хяналт тавьж удирдлага, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Болоржаргал), Хэсгийн мөрдөгч Ш.Ууганбаяр, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Ц.Саранчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМАРСАНАА